

**Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдийн үнэлгээ
/2022 оны эцсийн байдлаар/**

№	Төслийн нэр	Санхүүжүүлэгч	Эхлэх/дуусах хугацаа	Гэрээний үндсэн Валют *	Санхүүжилтийн дүн		Үүнээс		2022 оны үнэлгээ **	Төслийн хэрэгжилт (хувиар, өссөн дүнгээр) ***	Тайлбар/ хүрсэн үр дүн, тулгамдаж буй асуудал/
					Гэрээний үндсэн валютаар (мян. ...)	Төгрөгөөр (мян.төг)	Бүцэлтгүй тусламж	Зээл			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
НЭГ. АВТО ЗАМЫН САЛБАРТ											
1.1 Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн төсөл”											
1	Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын хяналтын зөвлөх үйлчилгээний ажил	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	2020-2023	\$	3,518.16	413,352,000.00	-	3,518.16	100%	50%	Энэхүү төслийн хүрээнд 2022 онд зам барилгын ажлын талбайд гадаад, дотоодын нийт 32 инженер, техникийн ажилчдаас бүрдсэн зөвлөхийн хяналтын баг нь авто замыг батлагдсан зураг төсөл, техник, технологийн шаардлагын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажилласан. Тулгамдаж буй асуудал: Зам барилгын ажлын гүйцэтгэгчийн гэрээний хугацааг сунгасантай холбогдуулан зөвлөхийн гэрээнд заасан инженер техникийн ажилчдын хүн сарын зардал дуусч байгаатай холбогдуулан гэрээнд өөрчлөлт оруулах саналыг санхүүжүүлэгч банкинд зөвшилцөж шийдвэрлэх шаардлагатай.
2	Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын Багц 1 дүгээр хэсэг буюу Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэлх 37.26 км авто зам барих төсөл	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	2020-2023	\$	12,692.41	43,720,260.67	-	12,692.41	100%	70%	Багц 1-р хэсгийн зам барилгын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн. Барилгын ажлын талбайд далангийн дээд үе болон дэд суурийн тэгшилгээ, нягтруулалт, цементээр бэхжүүлсэн суурь, суурь асфальтбетон хучилтын ажлыг дуусгаж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр нээсэн. Нийт ажлын гүйцэтгэл санхүүжилтийн өртгөөр 70.26 хувь, ажлын тоо хэмжээгээр 87.7 хувьтай байна. Тулгамдаж буй асуудал: Азийн хөгжлийн банкны төслийн замын хоёр талаар өргөсгөл бүхий 22 км авто замын хэсгийн өнгө асфальтбетон хучилтын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 2023 оны 06 дугаар сард багтаан дуусгаж, Европын сэргээн босголтын банкны төслийн замын гүйцэтгэгчид асфальтбетон хучилтын ажлаа саадгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Иймд тухайн АХБ-ны төслийн Багц 1-р хэсгийн нэмэлт 5 см асфальтбетон хучилтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах.
3	Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын Багц 2 дугаар хэсэг буюу Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто зам барих төсөл	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	2020-2023	\$	9,830.38	33,861,720.75	-	9,830.38	100%	53%	Багц 2-р хэсгийн зам барилгын ажлыг 2022.03.15-ны өдрөөс эхлүүлсэн. Барилгын ажлын талбай дээр далан, ухмалын ажил 100%, дэд суурь 71.8%, гүүр 61%, хоолой 100%, ЦБС 43.72%, ЦББЧС 35.5%, асфальтбетон хучилт 34.7% тус тус хийгдсэн. Нийт ажлын гүйцэтгэл санхүүжилтийн өртгөөр 37.93 хувь, ажлын тоо хэмжээгээр 53.01 хувьтай байна. Тулгамдаж буй асуудал: Тухайн зам барилгын ажил 2022 онд батлагдсан график төлөвлөгөөнөөс 39.96 хувийн хоцрогдолтой хэрэгжсэн тул барилгын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Захиалагчийн зүгээс гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, зам барилгын бэлтгэл ажлыг гүйцэтгэгчээр хангуулан ажиллаж байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
4	Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын Багц 3 дугаар хэсэг буюу Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто зам барих төсөл	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	2020-2023	\$	7,602.63	26,188,006.90	-	7,602.63	100%	48%	Багц 3-р хэсгийн барилгын ажлыг 2022.03.15-ны өдрөөс эхлүүлсэн. Барилгын ажлын талбай дээр далан, ухмалын ажил 100%, дэд суурь 64.6%, хоолой 92.1, ЦБС 22.2% тус тус хийгдсэн. Нийт ажлын гүйцэтгэл санхүүжилтийн өртгөөр 27.52 хувь, ажлын тоо хэмжээгээр 48.2 хувьтай явагдаж байна. Тулгамдаж буй асуудал: Зам барилгын ажил 2022 онд батлагдсан график төлөвлөгөөнөөс 39.96 хувийн хоцрогдолтой хэрэгжсэн тул барилгын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Захиалагчийн зүгээс гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, зам барилгын бэлтгэл ажлыг гүйцэтгэгчээр хангуулан ажиллаж байна.
5	Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын Багц 4 дүгээр хэсэг буюу Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км авто зам барих төсөл	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	2020-2023	\$	9,770.68	33,656,070.21	-	9,770.68	100%	66%	Барилгын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн. Барилгын ажлын талбай дээр далан, ухмал, дэд суурь, ЦБС, ЦББЧС, суурь асфальтбетон хучилтын ажлыг дуусгаж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр нээсэн. Нийт ажлын гүйцэтгэл санхүүжилтийн өртгөөр 53.27 хувь, ажлын тоо хэмжээгээр 66.5 хувьтай явагдаж байна.
6	Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын Багц 5 дугаар хэсэг буюу Цайдамын хөндийгөөс Дарханы тойрог уулзвар хүртэлх 28.84 км авто зам барих төсөл	Европын сэргээн босголт, хөгжлийн банк	2020-2023	\$	8,112.76	27,945,198.28	-	8,112.76	100%	65%	Багц 5-р хэсгийн барилгын ажлыг 2022.03.15-ны өдрөөс эхлүүлсэн. Барилгын ажлын талбай дээр далан, ухмал, дэд суурь, хоолой, ЦБС ажил 100%, ЦББЧС 79.4, асфальтбетон хучилт 63.3% тус тус хийгдсэн. Нийт ажлын гүйцэтгэл санхүүжилтийн өртгөөр 48.08 хувь, ажлын тоо хэмжээгээр 65.06 хувьтай байна. Тулгамдаж буй асуудал: Тухайн зам барилгын ажил 2022 онд батлагдсан график төлөвлөгөөнөөс 39.96 хувийн хоцрогдолтой хэрэгжсэн тул барилгын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Захиалагчийн зүгээс гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, зам барилгын бэлтгэл ажлыг гүйцэтгэгчээр хангуулан ажиллаж байна.
1.2 БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл											
1	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам барих төсөл	БНХАУ-ын Экспорт-Импортын банк	2019-2022	\$	18,687.21	64,369,965.94	-	18,687.21	100%	100%	Энэхүү авто замын барилгын ажил бүрэн дууссан бөгөөд тус яамнаас томилогдсонх ажлын хэсэг 2022.06.26-ны өдөр ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр улсын ашиглалтад хүлээн авсан. Улсын комиссын актын дугаар: 2022.11.22-ны өдрийн 06/12/22.
1.3 Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"											
1	Улаанбаатар - Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил (Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл)	Азийн хөгжлийн банк	2019 оноос 2026.09.30	\$	120,000.00	413,352,000	1,500.00	118,500.00	84.9%	83%	Төслийн барилгын ажил үргэлжилж байгаа ба 2022 оны эцсийн байдлаар барилгын ажлын явц 83 хувьтай байна. Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын барилгын ажил нь нийт 5 багцад хуваагдсан ба барилгын ажлын гүйцэтгэлийг багц тус бүрээр харуулбал: Багц 1-1 хэсэг: Нийслэлээс баруун аймгууд руу салах тойрог уулзвараас Хар модотын даваа хүртэлх 37.26 км авто замын ажлын явц 94.13 хувь; Багц 1-2 хэсэг: Хар модотын даваанаас Урьхан хүртэлх 45.5 км авто замын ажлын явц 87.72 хувь; Багц 1-3 хэсэг: Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто замын ажлын явц 94.39 хувь; Багц 1-4 хэсэг: Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км авто замын ажлын явц 47.13 хувь; Багц 1-5 хэсэг: Цайдамын хөндийгөөс Дарханы тойрог уулзвар хүртэлх 30.53 км авто замын ажлын явц 95.54 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
											Тулгамдаж буй болон шийдвэрлэгдэх шаардлагатай асуудлууд: Багц 1-1 хэсгийн гэрээг цуцлах шийдвэрийг 2023 оны 02 сарын 01-ний өдөр баталгаажуулж Азийн хөгжлийн банкнаас зөвшөөрөл авахаар хүсэлтээ хүргүүлсэн. Тус багцын гүйцэтгэлийг одоогийн байгаа байдлаар нь хүлээн авч, нэмэлт 5см асфальтбетон хучилтын тендэрт нэмэлтээр оруулах төлөвлөгөөтэй байгаа. Багц 1-3 хэсгийн нэмэлт 5см асфальтбетон хучилтын тендерийн сонгон шалгаруулалтын материалын бэлтгэл ажил удаашралтай байгаа ба гүйцэтгэгч компаниар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх боломжийг судлан ажиллаж байна.
	Хүйтний хөндий - Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын барилгын ажил		2019.06.20-оос 2023.07.01						100%	85.8%	Мөн тус төслийн хүрээнд хэрэгжиж буй Хүйтний хөндий - Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын барилгын ажлын явц 85.82 хувьтай байна. Тулгамдаж буй болон шийдвэрлэгдэх шаардлагатай асуудлууд: Онги голын гүүрний урсгал засварын зардал нь тус төслийн зардалд тусгагдсан боловч Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон зөвлөх компани, зураг төслийн компанийн хийж гүйцэтгэсэн шалгалтын үеэр тус гүүрэнд их засвар хийж шаардлагатай ба тус гүүр нь нурах, замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх өндөр магадлалтай байгаа талаар дүгнэлт гаргасан. Үүнтэй холбоотойгоор тус гүүрийн их засварын ажлын зураг төсөл гүйцэтгүүлэх болон түр зам угсралтын ажлыг гүйцэтгэгч компаниар хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.
	Дархан- Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засварын ажил		2023.06.20-оос 2023.11.20						--	--	Дархан- Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засварын ажил нь одоогийн байдлаар хийгдэж эхлээгүй байгаа ба 2023 онд сонгон шалгаруулалт хийгдэхээр төлөвлөгдсөн. Тулгамдаж буй болон шийдвэрлэгдэх шаардлагатай асуудлууд: ЗТХЯ, ТХН болон барилгын ажлын зөвлөх компанийн хамтаар тус авто замын аюулгүй байдлыг сайжруулахаар хэд хэдэн газарт барилгын ажил гүйцэтгэхээр болсон ба одоогийн байдлаар зөвлөх компани ажлын тоо хэмжээг тодорхойлохоор талбай дээр ажиллаж байна.
	Өндөрхаан-Норовлин-Дадал чиглэлийн авто замын эдийн засаг судалгааны ажил		2019.06.20-оос 2019.12.20						100%	100%	Өндөрхаан – Норовлин чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулах, судалгааны ажил хийгдэж дууссан.
1.4 “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” Төсөл 2											
1	“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” Төсөл 2	Азийн хөгжлийн банк	2014-2023	\$	109,066,076.72	375,689,007,870		109,066,076.72	94%	96.5%	Төслийн хүрээнд хэрэгжүүлэх нийт 4 багц хэсэг авто зам буюу 189.7 км авто замыг бүрэн ашиглалтанд оруулсан. Үүнд: 1. Багц CW1-1: Хашаатын даваа-Шургийн гүүр чиглэлийн 50 км авто замын хэрэгжилт 100 хувь. 2. Багц CW1-2: Шургийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км авто замын хэрэгжилт 100 хувь. 3. Багц CW1-3: Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км авто замын хэрэгжилт 100 хувь. 4. Багц CW1-4: Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замын хэрэгжилт 100 хувь. Мөн орон нутгийн туслах авто замууд: 5. Төслийн гол замаас Мөст сум чиглэлийн 20.3 км авто авто замын хэрэгжилт 100 хувь. Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто зам, гүүрийн ажлын хувьд: 6. Багц CW1: 6.76 км авто авто замын хэрэгжилт 100 хувь. 7. Багц CW2: 201.08 у/м төмөр бетон гүүр болон 260 м авто замын хэрэгжилт 80.28 хувь. 8. Багц CW3: 11.8 км авто замын хэрэгжилт 84.50 хувь.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
											<p>9. Баян-Өлгий, Ховд аймагт 2 төлбөр хураах цэг барих ажлын хэрэгжилт 100 хувь (Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төлбөр хураах цэг болон Ховд аймгийн Манхан сумын төлбөр хураах цэгийн барилгын ажил).</p> <p>10. Засвар, арчлалтын тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 100 хувь хийгдсэн (Гадаргуун боловсруулалтыг газар дээр нь хийх</p> <p>автомашин 1, РОМДАС системтэй авто замын эвдрэлийг бүрэн хэмжээнд, үзүүлэлт тус бүрээр нь нарийвчлан өндөр түвшинд тодорхойлох, орчин үеийн хэмжилтийн программ бүхий бш авто машин нийлүүлэгдсэн).</p> <p>Тулгамдаж буй асуудал: Төслийн 3129-МОН зээлийн гэрээг дахин сунгахгүй бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болгохтой холбоотойгоор Ховд-Баян-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км зам болон Ховд сум чиглэлийн 18.775 км авто замын барилгын ажлын гүйцэтгэчийг шалгаруулах тендерийг шуурхай зохион байгуулж, 2023 оны барилгын улиралд багтаан дээрх 2 авто замын барилгын ажлыг дуусгах шаардлагатай.</p>

ХОЁР. Иргэний нисэхийн салбар											
2.1 Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"											
1	Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Хэнтий аймгийн "Өндөрхаан онгоцны нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"	Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сан	2018.07.18 2023.06.30	\$	3,500.34	12,057,271.16	3,500.34		38%	66%	<p>Зам, тээврийн хөгжлийн яамнаас багц 1-ийн хувьд барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Барилга эрч" ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 154 дугаартай "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан. Багц 1 барилгын ажлын санхүүжилт 25,3 хувь буюу 1,365,674,339.00 төгрөг, ажлын гүйцэтгэл 35,4 хувьтай байна. Багц 2 аэродромын ажлын санхүүжилт 84,2 хувь буюу 3,701,001,976 төгрөг, ажлын гүйцэтгэл 98 хувьтай байна.</p> <p>Тулгамдаж буй асуудал: 1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үй ажиллагаанд ашиглагдаж байсан УНЭ 77-49 улсын дугаартай автомашиныг "Монголын төмөр зам" ТӨХК-нд 2022 оны 05 дугаар сарын 03-нд шилжүүлснээс хойш одоог хүртэл автомашинтай болж чадаагүй байна. Үүнээс үүдэн төслийн барилга угсралтын ажилд мэргэжлийн хяналт тавьж чадахгүй нөхцөл, байдал үүссээр байна.</p> <p>2. Санхүүжилтийн гүйцэтгэл удааширсан. Багц-1 барилгы ажлын гүйцэтгэчийн эхний санхүүжилтийн гүйцэтгэл 121 хоногийн дараа, багц-2 аэродромын ажлын гүйцэтгэчийн 5 дахь санхүүжилтийн гүйцэтгэл 109 хоногийн дараа гүйцэтгэчийн дансанд тус тус орсон.</p> <p>3. Барилгын материалын үнийн өсөлт, цементийн хомсдолос шалтгаалж барилгын ажил удааширалтай явагдсан.</p> <p>4. Барилгын чанарын баталгааны 5 хувийг аль байгууллага дансанд байршуулах нь тодорхой бус байна.5. Аванперр болон перроны хөвөөний ажил, гүний худгийн ерөмдлөгийн ажил төсөвт тусгагдаагүй бөгөөд магадлашгүй ажлын зардлаар хийж гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна.</p> <p>6. Аэродромын ажлын гүйцэтгэгч, Хэрлэн сумын ЗДТГ хоорон орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн асуудлаар маргасаар аэродромын нислэгийн зурвасны /2800x150м талбай/ перроны хөвөөний тэгшилгээний ажил дуусаагүй.</p> <p>7. Перроны бетон хучилтын зарим засварын ажил цаг агаа хүйтэрсэн тул зогссон.</p>

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ГУРАВ. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР											
1	"Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэг (EARC)-ийн үүсгэн байгуулалттай уялдах нь" төсөл	БНСУ -ын Засгийн газар	2022.06.07-2024.12.07	\$	2,460,000.00	8,473,716,000.00	2,460,000.00	-	30%	30%	Төслийн хүрээнд Монгол Улсын зүүн хөндлөн (Сайншанд-Баруун-Урт-Хөөт) болон баруун хөндлөн (Нарийнсухайт-Даланзадгад-Тавантолгой) чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, төмөр замын бүтээн байгуулалтын санхүүгийн загвар, удирдлагын схем боловсруулах, Монгол Улсын логистикийн хөгжлийн стратеги болон бодлогыг хөгжүүлэх гэсэн 3 зорилтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Сонгогдсон чиглэлд төмөр замын 2 трассын дагуу газарзүйн судалгааны ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран 1:25000 масштабтай хийхээр ажиллаж байна. Төслийн инженерийн судалгаа хийж буй Юушин инженеринг корпораци сонгогдсон чиглэлийн дагуу трассын судалгаа хийж байна. Төслийн ТЭЗҮ боловсруулахтай холбогдуулан Солонгосын төмөр замын корпорацийн Тээвэр, хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан газрын дарга Чон Юун Хван, Гадаад хамтын ажиллагааны мэргэжилтэн И Жун Юн нартай 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр уулзалт хийж, ТЭЗҮ-ийн галт тэрэгний ашиглалт, үйл ажиллагааны хэсгийн тайлан боловсруулахад шаардлагатай мэдээлэл авсан, мөн МТЗ ТӨХК тэй уулзалт хийн судалгаанд шаардлагатай материалыг авахаар болсон. Төслийн эхний жилийн тайланг БНСУ-ын консерцумын талаас 12 дугаар сарын 1-ний өдөр ирүүлсэн.
2	MON TA 8935: Богдхан тойруу төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөл	Азийн хөгжлийн банк	2021.06.28-2022.01.28	\$	1,160,000.00	3,995,736,000.00	1,160,000.00	-	100%	100%	Франц Улсын "Систра" компани болон Монгол Улсын "Эм Си Пи, Си Жи Ар" компанийн нэгдлээс 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр төслийн Англи, Монгол хэл дээрх эцсийн шатны тайланг ирүүлсэн.
3	"Монгол Улсын Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв (ГТХЗНТ)-ийн барилга барих, түүний үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх" төсөл	КОЙКА	2021.08.16-2026.06.30	\$	14,000,000.00	48,224,400,000.00	14,000,000.00	-	30%	50%	Нийслэлийн ерөнхий архитектороор 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн МЗХ2022/02-005 дугаартай "Архитектур төлөвлөлтийн даалгавар"-ыг батлуулсан. Төслийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдөр зарласан. Төслийн Ажлын даалгаврын "В" хэсэгт тусгагдсан "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв"-ийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөхийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарлаж, хамгийн сайн үнэлгээтэй "Эм Эс Эл" ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага, "Эм Эс Эл" ХХК, "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ болон Зам, тээврийн хөгжлийн яам хамтарсан гэрээ байгуулсан.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ГАРЫН ҮСЭГ /ТАМГА/

Тайлбар:

* Гэрээний үндсэн валют-USD, EUR, JPY, SDR

** Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлгээг хийнэ.

*** Төслийн хэрэгжилтийг хувиар тооцож гаргана.

****Агентлагууд дээр хэрэгжиж буй төслүүдийг хамруулна